




Үүсгэн байгуулагчийн сургаал

Наминчлал бол шинэ замналын эхлэл

Энэ жилээ эргэн харахад “үүнийг ямар ч байсан хийж дуусгадаг юм шүү” гэж шийдсэн байсан зүйлээ хийж чадаагүй, сэтгэлээр унах хүн байж магадгүй. Гэвч шийдсэн байсан ч хэрэгжүүлэх гэдэг ямар хэцүү болохыг мэдсэн гэдэг нь өмнөхөөсөө нэг шат ахисны илэрхийлэл гэж бодно.

“Сайн хүн аз жаргалд хүрч чадна. Тиймээс муу хүн ч хэлэх юун” хэмээх Японы Шинран ламтны хэлсэн алдартай үг байдаг. Эсрэгээр нь хэлвэл дээрх эшлэлийн утга илүү тодорхой болно. “Ямар ч муу хүн байсан бурхан багш агуу уужим нигүүлсэнгүй сэтгэлээр авардаг тул сайн хүнийг бол аврахгүй орхих учиргүй” гэж хэлвэл илүү ойлгомжтой болох шиг санагдана.

Гэтэл “би огтхон ч алдаа гаргаагүй” хэмээн өөрийгөө хэт үнэлвэл бурхан багшийн авралыг

ч тэр, сургаалыг ч тэр хүртээ хэмээн хүсэхгүй болчихно. Өөрийнхөө дутагдал, сул талыг жинхэнэ утгаараа ойлгосон хүн бол сургаалаас суралцахгүй байж чадахгүй. Ингэж ойлгосон хүн бол бурханд хамгийн ойрхон байгаа хүн гэж ойлгож болно.

Өөрийгөө сул дорой, алдаа гаргадаг хүн гэдгээ мэдчихвэл хийхээр шийдсэн зүйлээ чадаагүй байлаа ч дахин шинээр эхлүүлэхэд болно. Энэ жил чадаагүй ч ирэх жил заавал биелүүлнэ гэж шийдэхэд болно гэсэн үг. Ингэж чадвал хүсэл тань биелэх нь зайлшгүй. Наминчлал гэдэг нь шинэ шийдвэр гаргаж, урагшаа нэг алхам ахихыг хэлж байгаа юм.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, 104-105х

Living the Lotus Vol. 159 (2018.12)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Б. Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Амьдралын үүрэг даалгавараа ухаарах нь

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Хийж буй зүйлээсээ таашаал авдаг хүн болохын тулд

Эдогийн төгсгөлийн үед амьдарч байсан Фүкүи мужийн яруу найрагч Акэми Тачибана (1812–68он) нь амьдралд байдаг энгийн зүйлсийг талархал, баяр баясалаар дүүрэн, аз жаргал баялхсан шүлэг болгон илэрхийлэхдээ гаргуун нэгэн байсан.

“Баяр баясал гэдэг цаас дэлгээд бийрээр үг бичихэд гар минь эвлэж, санаснаас ч сайхан үсгийг бичих үе юм”, “баяр баясал гэдэг нь эхнэр хүүхдүүд минь эвтэй байж, идэх хоолоо толгой дохин амтархан идэх үе юм”, “баяр баясал гэдэг нь өглөө босоод хармагц өчигдөр байгаагүй цэцэг ургасан байхыг олж харах мөч юм”... . “Баяр баясал гэдэг нь” хэмээх энэ шүлэгнээс ямар ч үед аливаа зүйлийг талархал дүүрэн хүлээж авдаг хүний сэтгэлийг мэдрэх болно.

Бид 8н сарын турш “Хутагтын найман зөв зам” сургаалыг цувралаар суралцсан ба миний бие өөрийнхөөрөө тус сургаалын утга агуулгыг тайлбарлаж ирсэн. Ингээд энэ сард “Хутагтын найман зөв зам”-ын хамгийн төгсгөлд дурьдагддаг “зөв бясалгал” дээр ирээд байна. “Зөв бясалгал” гэдэг нь сэтгэлдээ үргэлж Бурханы сургаалыг тээж, эргэн тойрны өөрчлөлтөнд автаж, сандардаггүй байхыг хэлнэ гэж ойлгож болно. Ядуу тарчиг байсан ч гэсэн сэтгэлээр уналгүй, өөрт оногдсон аз жаргалаа мэдэрч, түүндээ талархаж чаддаг Акэми Тачибанагийнх шиг сэтгэл ч гэсэн “зөв бясалгал”-ын нэг илэрхийлэл бизээ. “Хөгжилтэй”, “таашаал авах” гэдэг нь маш чухал зүйл бөгөөд “Хутагтын найман зөв зам”-ын хамгийн эхний “зөв үзэл” гэдгийг “сэтгэл хөнгөрч, амгалан болох үзэл” (2018 оны 5-р сарын дугаар) гэж өмнө нь тайлбарласан удаатай.

“Күнзийн эш номлол”-д ч “түүнийг мэддэг хүн түүнд дуртай хүмүүний хэмжээнд үл хүрмүй. Түүнд дуртай хүн түүнээс таашаал авдаг хүмүүний хэмжээнд үл хүрмүй” гэсэн үг байдаг. Өөрөөр хэлбэл хүн бурханы зам мөрийг дагаж эзэмшье гэвэл тэрхүү зам мөрөөр баяр баясалтай алхаж, таашаал авдаг болох хэрэгтэй гэсэн утгатай.

Ямар ч зүйлийг хөгжилтэй хэмээн хүлээн авах –ийм л үзлийг өөртөө хэвшүүлэхийг оролдвол сэтгэл хөнгөрч, жижиг сажиг бэрхшээлд хөл алдах зүйлгүй жинхэнэ амар амгалан амьдралыг туулж чадна.





Хүсэл мөрөөдлийг тээж

“Хутагтын найман зөв зам”-ын “ЗӨВ” гэдэг ханз үсэг 2 зурлагнаас бүтэх ба нэг нь “үнэн, ном, сургаал” хэмээх ханз, нөгөөх нь “зогсох” гэсэн утгатай ханз юм. Өөрөөр хэлбэл “Хутагтын найман зөв зам”-ын хэсэг тус бүр “үнэн дээр зогсох”-ын төлөөх хэрэгжүүлэлт ба түүний суурь нь хамгийн эхэнд дурьдагддаг “зөв үзэл” гэж хэлж болно. Хэрэв “Хутагтын найман зөв зам”-ын бүх хэсгийг хэрэгжүүлэх хэцүү байна гэх хүн байвал, ямар нэг зүйл болоход тэр дороо “зөв үзэл” лүү буцаж чаддаг хэвшил өөртөө бий болгох нь чухал гэж бодож байна.

Ялангуяа асуудалтай тулгаран, яахаа мэдэхгүй бачимдаж байгаа үед “үнэн”, зөв үзэл лүү буцах гэсэн утгаараа тохиолдоод буй зүйлийг зөвөөр харвал юу сэтгэлийг зовоож байна вэ? Яавал сэтгэл хөнгөрөх вэ гэдгийг мэддэг болно.

Ийм үнэнд нийцсэн амьдралыг хүсэмжилдэг хүмүүсийг буддизмд “зөв бясалгалын андуудын цуглаан” хэмээн нэрлэдэг. Ерөнхийдөө “бурхан шиг болохоор шийдсэн хүмүүс”-ийг нэрлэж байгаа ба энэ үгнээс “зөв бясалгал” утгыг илүү гүнзгий ойлгож болно.

Бурхан лугаа аливаа зүйлийг байгаагаар нь харснаар (зөв үзэл) амар амгалангаар бялхсан сэтгэлийг (зөв бясалгал)-ыг олмуй. Энэ нь “тэр хүний зовлонг байхгүй болгомоор байна”, “энэ хүнийг нигүүлсэнгүй сэтгэлтэй болгохсон” гэсэн бодисадвагийн хүслийг тээж амьдрахыг хэлнэ.

Харин дээрх шиг тангарагт хүрэх арга нь мэдээж “зөв үзэл”-р хязгаарлагдахгүй. “Хутагтын найман зөв зам” нь найман хэсэгт хуваагдсан байгаа нь ч “хүн бүр өөрийн онцлогтоо таарсан аргаар сургаалыг хэрэгжүүлж болно” хэмээх Шагжамүни бурхан багшийн энэрэнгүй сэтгэлийн илэрхийлэл билээ.

Хүмүүс бид бүгдээрээ бие биесийнхээ ач тусыг хүртэж, дэм дэмэндээ амьдарч байдаг. Ялангуяа бурханы сургаалаар дамжуулж хүмүүний амьдралын мөн чанарыг суралцдаг бид бүхэн бурхан болон гэгээрэх зам мөрөөр алхангаа аль болох олон хүний бурханлаг чанарыг нээх хэмээх амьдралын үүрэг даалгавараа биелүүлэх хэрэгтэй гэж бодож байна.

“Косей” сэтгүүл 12-р сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Үлгэрлэл 3-р бүлэг (2-р хэсэг)

Бурханы хүч ба өөрийн хүч

Эхлээд баян ноён “би их хүч чадалтай тул бүх хүүхдийг том хайрцаганд хийгээд гадагшаа авч гаран, амийг нь аваръя” гэж бодсон боловч дахин сайтар бодоод ерөөсөө хүүхдүүдийг өөрсдийнх нь хүчээр гадагшаа гарахаар зохицуулъя... гэсэн хэсэг гарсан.

Энэ нь “бурханы хүч” болон “өөрийн хүч” юугаараа ялгаатай вэ гэдгийг далдуур илэрхийлж байгаа хэрэг. Юу ч хэлэхгүйгээр хамаг амьтныг зовлонгийн ертөнцөөс татан гаргаж болно. Энэ бол бурханы хүч. Гэтэл хамаг амьтад түр зуурыг зугаа цэнгэл, баяр баясалд хэт автсан байгаа тул авралын хайрцагнаас өөрөө уначихаж магадгүй. Давчуу тухгүй хайрцаганд байхаас илүүтэй ундуй сундуй ч гэсэн цэлгэр том байшинд тоглох нь илүү сонирхолтой санагдах учраас. Өөрөө л ухамсарлаж ойлгохгүй бол ийм байдалд ороход амархан. Мөн шатаж буй байшингаас нэг удаа гаргаж өглөө гэхэд гаднахаас илүү байшин доторх байдалд татагдаад буцах хүн ч цөөнгүй байж болно.

Тиймээс бурхан багш хүүхдүүдийг өөрийн хүчээр яаж ийж байгаад аврагдахаар чиглүүлнэ. Хүмүүс аль ч шатны авралыг хүсэж гүйн гарч болно. Хонин тэрэг, буган тэрэг, үхэр тэрэг алийг нь ч хүссэн бай “өөрийн ухамсараараа хаалганы гадна гарах” гэдэгт гол утга оршиж байгаа юм. Өөрийн ухамсар, шийдвэрээр гарсан бол баргийн зүйл л тохиолдоогүй бол эргэж буцах учиргүй. Шашин шүтлэг ч гэсэн ийм байх ёстой. Бурхан, сахиуснаас зөвхөн “аварч хайрлаач” гэж гуйхаас өөр зүйлгүй, өөрийн сэтгэлийг сайжруулж, үйлдэлээ засах оролдлого хийхгүйгээр жинхэнэ авралд хүрч чадахгүй. Өөрийн ухамсараар, дотоод хүчээрээ бурханы үйлийг хийснээр, сэтгэлээ сайжруулж жинхэнэ авралд хүрч чадна.

Гэвч сэтгэлээ сайжруулах бурханы үйлийн

эцсийн цэг нь хаана хүргэх вэ гэвэл өчүүхэн “аминч үзэл” –ээ таягдан хаяж, тэнгэр газрын хуулинд захирагдаж, бурханы агуу энэрэл нигүүлсэлтэй нэгдэн бүхэл болохыг хэлнэ. Тиймээс энд гарч байгаа “өөрийн хүч” гэдэг нь огтхон ч “би, би” гэсэн “хувиа хичээсэн аминч үзэл” биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл өөрийн хүчээр бий болгосон сүсэг бишрэл гэдэг өөрийн ухамсар, хичээл зүтгэлээр бурханд сүсэглэх, аврал одуулахыг хэлнэ.

Өөрийн хүч гэдэг бурханы хүч, бурханы хүч гэдэг өөрийн хүч гэсэн үг байдаг. Өөрийн хүчээр ийнхүү сүсэглээд, бурханы авралд багтсанаар жинхэнэ авралд хүрэх болно. Үлгэрийн дээрх хэсэг ийм далд утгыг илэрхийлжээ.





Хувиа хичээсэн, аминч үзлээ хаях

Дараа нь жижигхэн хаалга ганцхан байжээ... гэсэн хэсэг гарсан. Ганцхан хаалга гэдэг нь “хувиа хичээсэн, аминч үзлээ хаях” гэсэн сэтгэлийн маш том өөрчлөлтийг хэлж байгаа юм. Энгийн хүмүүсийн хувьд энэ нь маш хэцүү даалгавар тул жижиг давчуу хаалга гэдгээр дүрсэлсэн хэрэг.

Энэхүү “хувиа хичээсэн, аминч үзлээ хаях” гэдэгт хэд хэдэн үе шат байдаг. 1-р үе шат нь “амьдралын том зовлон нь хувиа хичээсэн үзлийн бөөгнөрөл болсон янз бүрийн шуналаас үүсдэг” гэсэн зарчмыг ойлгох хэрэгтэй. Энэ зарчмыг ойлгох төдийд хувиа хичээсэн үзлээсээ багагүй салж чадна. Гэвч энэ шат нь хувиа хичээсэн үзлийг үүсгэх зарчмыг бүрэн ойлгох шат биш тул хангалттай биш.

Дараагийн 2-р үе шат бол “шүтэн барилдлага”-аар бидний өөрийн болгохыг тэгтлээ хүсэж, шунадаг зүйлс нь бүгд дотоод ба гадаад шалтгааны нийлбэрээс үүсдэг түр зуурын илрэл гэдгийг ойлгоно. Түүнчлэн “12 шүтэн барилдлага”-ын хуулиар дамжуулж дээрх шиг шуналын үндэс нь харанхуй буюу “билиг оюунгүй” байдал гэдгийг мэдэх хэрэгтэй.

Эдгээр хуулиудыг ойлгож, ухаарвал өдийг хүртэл тас зуурч байсан аминч үзэл хэмээгч зүйл нь үнэндээ бодот биегүй зүйл байж гэдгийг ойлгоно. Улмаар хувиа хичээсэн, аминч үзлээс өөрөө биеэ татан холдож чадах болно.

Бүр шат ахивал “энэ сансар огторгуйн бүх зүйлс угтаа бүгд эрх тэгш бөгөөд хоорондоо агуу барилдлагатай” гэсэн үнэнийг ойлгож чадна. Бүх хүн эрх тэгш бурханлаг чанартай бурханы үрс юм. Тиймээс бүгд ахан дүүс гэсэн нэгдмэл байдлыг гүн гүнзгий мэдрэх болно. Энэ шатанд хүрвэл, аминч үзэл нь ор үндэсгүй алга болох бөгөөд түүний бараа сураг ч байхгүй болно.

Эзэн, багш, эцэг эхийн гурван эрхэм чанар

Энэ бүлэгт бурханы сургаалын бүх судар дотроос онцгой нандин гэж хэлэгддэг



алдартай шүлэг багтдаг.

“Би бээр өдгөө гурван орон эзэгнэхүй еэ амьд бүхнийг өөрийн хөвгүүн мэт үзэн, өдгөө өвчин зовлонд нэрвэгдэгсэдийг би бээр эн тэргүүнд авран үзэх больюу.”

Энэ сансар огторгуй бүхэлдээ минийх. Хамаг амьтан хийгээд бүх хүн төрөлхтөн миний үр хүүхэд юм. Эдгээр үр хүүхдүүдийг зовлон бэрхшээлээс салгаж чадах хүн надаас өөр байхгүй- гэсэн утгатай. Шагжамүнигийн энэхүү айлдвар нь “сансар огторгуй бол минийх” гэж өмчилж байгаа хэрэг биш бөгөөд “зөвхөн би л аварч чадна” гэж бардамнаж байгаа ч хэрэг биш юм. “Ямарч хүнд бурханлаг чанар байдаг. Тиймээс би бүх хүнд тэр үнэнийг ойлгуулж, нэг ч хүнийг үлдээлгүй надтай ижил буддын гэгээрэлд хүргэмээр байна” гэсэн утгатай юм.

Ничирэн ламтан энэ шүлэгнээс “эзэн, багш, эцэг эхийн гурван эрхэм чанар” гэсэн ойлголтыг гарган ирж, Шагжамүни бурханы буяныг магтан дуулсан байдаг.

Эзний эрхэм чанар бол эх болсон зургаан зүйл хамаг амьтныг хамгаалж, авралдаа багтаах. Багшийн эрхэм чанар бол хамаг амьтныг сургаалаар зөв чиг лүү хөтлөх. Эцэг эхийн эрхэм чанар бол хамаг амьтныг энэрэн



төрөл садан, анд нөхөр болой. Тиймээс тэдэнд эцэг эхийн сэтгэлээр хандахгүй бол болохгүй. Энэ нь жинхэнэ их нигүүлсэл бөгөөд бурханы түвшинд хүрч байж л ийм сэтгэл төрөх бизээ.

Дээрх утга агуулга тус бүлэгт мөн л далд хэлбэрээр дүрслэгддэг. Яагаад гэвэл дээрх үгийг огцом гаргаад хэллээ ч гэсэн ойлгоход туйлын бэрх учраас юм. Тиймээс Шагжамүни бурхан үүний дараах бүлгүүдэд ч туйлын тэвчээртэйгээр урт айлдваруудаа үргэлжлүүлдэг. Далд утгатай хэсгийг цухас дурьдаж, хүмүүсийн анхаарлыг нь татсанаар дараа нь хэзээ нэгэн цагт үндэс нь нахиалах учиртай гэдгийг Шагжамүни бурхан багш сайн мэдээд, үргэлжлүүлэн дээрх шиг далд утгатай хэсгийг айлдсаар байх болно.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X 49-56

хайрлахыг хэлнэ.

Ничирэн ламтан нь гүн гүнзгий эргэцүүлэл, мөн шашинтай холбоотой янз бүрийн өөрт нь тохиолдсон явдлуудаас улбаалан Цагаан Лянхуа судрыг чин сэтгэлээсээ хэрэгжүүлдэг хэнд ч дээрх шиг гурван эрхэм чанар цогцлох болно гэж айлджээ.

Түүнчлэн энэхүү шүлгийг дараах байдлаар хүлээн авч болно. Бид бүхэн жинхэнэ утгаараа аминч үзлээсээ салж чадвал бүх зүйлсийн ач буянаар оршин тогтнож байгаа гэдгээ олж мэдэх болно. Улмаар сансар огторгуйн бүхий л зүйлсийн тусламжтай амьдарч байгаа өөрийгөө гүн гүнзгий мэдэрч чадвал сансар огторгуйн хаа сайгүй тархаж, мэдрэх болно.

Ийм түвшинд хүрмэгц сэтгэл зүрх орон зай цаг хугацаанд захирагдахгүй эрх чөлөөтэй болно. Юунд ч баригдахгүй бөгөөд санааны зоргоороо байсан ч бүх үйл нь үнэн (ном, дарма)-ээс гажих зүйлгүй, өөрийгөө болон бусдыг амьдруулах үйл болох болно.

Түүнчлэн сансар огторгуй нь минийх юм бол түүн дотор амьдарч байгаа хамаг амьтад миний үр хүүхэд болох бөгөөд хоорондоо

Амьдралын үүрэг даалгавараа ухаарах нь

12-р сар гарч бүтэн жилээ эргэн дүгнэх үе ирээд байна. Тэр тусмаа РКК байгууллагын хувьд шинэ жил 12-р сараас эхэлдэг уламжлалтай.

Ерөнхийлөгч маань жилийн энэ үед тааруулан “амьдралын үүрэг даалгавараа ухаарах” гэсэн сэдвээр сургаалаа айлджээ. 5-р сараас эхлэн, найман удаагийн цувралаар “Хутагтын найман зөв зам” сургаалыг суралцаж ирлээ. Энэ сард төгсгөлийн “зөв бясалгал” дээр ирээд байгаа ба юу ч хийсэн түүнээсээ таашаал авах нь чухал гэж сурч авлаа. Цаашлаад хүсэл мөрөөдлийг тээн бурханы зам мөрөөр нэг шат ахих нь ямар чухал болохыг ойлголоо.

Ариун ордны ном уншлагын үүрэг анх авахад “бүх зүйл гараа хавсран залбирахаас эхэлж, мөн түүгээр дуусна” гэж заалгасан. Гараа хавсран залбирах үйлийг хэрэгжүүлснээр сурсан зүйл бол яах аргагүй талархалын сэтгэл юм.


Ирэх жил РКК нь АНУ-д сургаал түгээсний 60 жилийн ой тохино. Үүний зэрэгцээ манай байгууллагын олон улс дахь сургаал түгээлт эхэлсний 60 жилийн ой ч давхцаж байгаа. Дэлхий дахины хүмүүст ариун нандин сургаалыг дамжуулах үүрэг даалгавараа ухаарч, бусдын бурханлаг чанарт мөргөн залбирах сэтгэлээр гэгээлэг, хөгжилтэйгөөр урагшаа явцгаая!

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Сайтоо Коичи



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Jhongjheng District,
Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Patna****Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax: 39-06-48913949 e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris****Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia